



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн өргөн
чөлөө 3, Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101 Утас: (976) 70442273
Цахим шуудан: info@bayanhongor.gov.mn
Цахим хаяг: www.bayanhongor.gov.mn

2023. 07. 05 № 2/1031

танай _____ -ны № _____ -т

Г ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ Г

ГАЗАРТ

Иргэдээс төрийн захиргааны байгууллага,
албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл,
гомдлын шийдвэрлэлтийн 2023 оны эхний хагас
жилийн тайлан мэдээг хүргүүлж байна.

Хавсралт 5 хуудастай.

ДАРГА



Д.ЭНХЖАРГАЛ

623291356

**ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН
ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**

2023 оны 07 дугаар сарын 05

Номгон

Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, Нутгийн захиргааны байгууллагууд нь иргэдээс санал, хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэхдээ “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2014 оны 202 дугаар захирамжаар батлагдсан “Төрийн байгууллага, албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангаж, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, тэдний санал, хүсэлтийг бодлого шийдвэртээ тусгаж ажиллах зарчмыг баримтлан ажиллалаа.

Аймгийн хэмжээнд төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн нийт 4581 санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авснаас аймгийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт 181 санал, хүсэлт, өргөдөл, гомдол, Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлагт 3212, сумдын Засаг даргын Тамгын газарт 1188 санал, хүсэлт, өргөдөл, гомдол ирсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт бичгээр 89, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 11-11 төвөөс 92 өргөдөл ирснээс 141 буюу 86 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж 16 өргөдөл гомдлыг холбогдох байгууллагад шилжүүлж, хугацаа болоогүй судалж байгаа 24 санал хүсэлт байна.

Нийт ирсэн өргөдлийг агуулгаар нь ангилж үзвэл ажил хүссэн 6, гэр хүссэн 3, газрын асуудлаар 8, мөнгөн тусламж хүссэн 17, бусад асуудлаар 147 өргөдөл, хүсэлт ирсэн байна.

Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой болон эмчилгээний зардал, мөнгөн тусламж хүссэн 2 иргэнд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 900.000 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олголоо.

Аймгийн Засаг даргад ирүүлсэн дээрх гэр хүссэн 3 өргөдлийн 1-ийг нь аймгийн Засаг даргын Тамгын газрын хамт олон сонгон авч, нэг өдрийн цалин болох 2,730,0 мянган төгрөгийн хандив цуглуулж, шинэ 4 ханатай гэр худалдан авч өгсөн. Тус иргэн нь 3 хүүхэдтэй, өрх толгойлсон эмэгтэй бөгөөд айлын гэр түрээсэлж, гэр бүлийн хүчирхийлэлд амьдарч байсан эмэгтэй юм.

Цахим аймаг болох зорилтын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газарт www.eoffice.bayanhongor.gov.mn, иргэдээс төрийн байгууллага албан тушаалтад хандан гаргах санал хүсэлт, өргөдөл гомдлыг цахимаар хүлээн авах, төрийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой сэтгэл ханамжийн судалгаа авах www.irgen.bayanhongor.gov.mn системийг тус тус нэвтрүүлсэн.

Энэхүү системүүдийг нэвтрүүлснээр иргэдээс төрийн байгууллага албан тушаалтад хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн бүртгэл, шийдвэрлэлтийг бүрэн цахимжуулж шийдвэрлэлтийн явц, хугацааг байгууллага тус бүрээр бүрэн хянах, иргэдэд чирэгдэл үүсгэхгүй, санал хүсэлтийг цахимаар гаргах боломжийг бүрдүүлж байна.

Энэхүү систем нэвтэрсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны А/158 дугаар захирамжаар “Төрийн байгууллага, албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг нь хангаж ажиллаж байна.

Иргэдээс Баянхонгор аймгийн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг хүснэгт 1, өргөдөл, гомдол, санал, хүсэлт хэлбэрээр хүснэгт 2, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн агуулга хувийг хүснэгт 3-аар тус тус нэгтгэн гаргалаа.

ХЯНАСАН:


ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА

Д.ЭНХЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.НАРАНЦЭЦЭГ



ИРГЭДЭЭС БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

2023 оны 07 дугаар сарын 05

Номгон

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлтийн хувиар
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шилжүүлсэн	Хугацаа болоогүй	
1	Засаг даргын Тамгын газар	181	141	16		24	86%
2	Хэлтэс агентлаг	3212	3136	6		70	98.8%
3	Сумын ЗДТГ	1188	1013	1		174	85.3%
Дүн		4581	4290	23		268	94%

ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА



Д.ЭНХЖАРГАЛ

МЭДЭЭ НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.НАРАНЦЭЦЭГ

ИРГЭДЭЭС БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ ХЭЛБЭРЭЭР

2023 оны 07 дугаар сарын 05

Номгон

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо	Үүнээс					
			Бичгээр	11-11 төв болон 7044001 дугаараар	Цахим хэлбэрээр	Утсаар	Биечлэн уулзсан	Бусад
1	Засаг даргын Тамгын газар	181	89	92				
2	Хэлтэс агентлаг	3212	1494	13	344	849	512	
3	Сумын ЗДТГ	1188	1181	3	3	1		
Дүн		4581	2764	108	347	850	512	

ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА



Д.ЭНХЖАРГАЛ

МЭДЭЭ НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *Б.НАРАНЦЭЦЭГ*

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТИЙН
АГУУЛГА ХУВЬ

2023 оны 07 дугаар сарын 05

Номгон

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал Тоо нийт өргөдөл, гомдлын эзлэх хувь
1	Баянхонгор	Нийт 4581 өргөдлөөс
		1.Хүсэлт- 4479 (98%) 2.Санал- 0 (0%) 3.Гомдол- 102 (2%) Ажил хүссэн- 253 (5%) Тусламж дэмжлэг хүссэн- 263 (5%) Газрын асуудлаар- 154 (3%) Гэр хүссэн- 10 (0.1%) Нийгмийн даатгалын асуудлаар- 195 (4%) Нийгмийн халамжийн асуудлаар- 973 (21%) Иргэний бүртгэлтэй холбоотой асуудлаар- 144 (3%) Худалдаа үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл хүссэн- 344 (7%) Бусад асуудлаар- 2245 (51%)

ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА



Д.ЭНХЖАРГАЛ

МЭДЭЭ НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *Б.Наранцэцэг* Б.НАРАНЦЭЦЭГ